



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.06.02 № 25

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Асуулга тавих тухай

Ховд аймгийн Хар-Ус нуурын ай сав, арлуудад нутагшуулсан заарт хархны /ондатр/ тоо толгой сүүлийн жилүүдэд хэт олшрон 100.000 /нэг зуун мянга/ хүрч малчдын хадлан тэжээл бэлтгэх талбай усанд автах, малын бууц хэвтэргүй болох, нуурын зэгс, хулс, ургамал ховордох зэргээр нуурын экологийн тэнцвэрт байдал алдагдаж, Ховд аймгийн 5 сумын 500 гаруй малчид өвөлжөө, хаваржаагүй болох нөхцөл байдал үүсээд байна. Хар-Ус нуурт 60 гаруй арал байдгаас 30 орчим арал нь уг амьтнаас болж унаган төрхөө алдаж сүйдсэн талаар судлаачид, нутгийн иргэд мэдээлэл ирүүлсэн байна. Мөн нутгийн иргэд заарт харх агнаснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутагт амьтан агнасан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэгт холбогдох, Зөрчлийн хуулиар шийтгүүлэх явдал гарсаар байна.

Түүнчлэн баруун бүс нутаг ялангуяа Ховд аймгийн нутаг дэвсгэрт саарал чонын тоо толгой огцом өсөж, малчин иргэдийн малд ихээр халдаж амьжиргаанд нь сөргөөр нөлөөлөх болжээ. Гэтэл малчдын хоттой мал, мал хариулж буй хүн рүү чоно дайрсан гарцаагүй тохиолдолд чоно агнасан малчин нь Амьтны тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээж, торгууль төлж, эд зүйлсээ хураалгаж байна. Өөрөөр хэлбэл малчид хууль зөрчихгүйгээр чоно агнахын тулд заавал сургалтад сууж, сумын Засаг даргаас урьдчилан зөвшөөрөл авч, төлбөр /102000-240000 төгрөг/ төлөх зэрэг олон шат дамжлага дамжин чоно агнах зөвшөөрөл авах зохицуулалттай байна.

Заарт харх, саарал чонын тоо толгой өссөнөөс үүдсэн дээрх сөрөг нөлөө, хуулийн зохицуулалт нь бодит амьдрал дээр олон хүндрэлийг үүсгэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Заарт харх нь Хар-Ус нуурын байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа талаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн эсэх, мөн Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2016

онд 30000 тоо толгой заарт харх агнуулах зөвшөөрөл авсан боловч өнөөдрийг хүртэл агналт зохион байгуулаагүй учир шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар,

2. Талын чоно агнахыг хориглосон хуулийн заалтыг зарчмын хувьд дэмжиж байгаа болно. Харин сүүлийн жилүүдэд алтайн болон хангайн чонын тоо толгой хэт өсч хүн малруу дайрах эрсдэл эрс нэмэгдэх боллоо. Үүнтэй холбогдуулан бүс нутгийн онцлог, үүсээд буй бодит нөхцөл байдалд нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх талаар баримталж буй бодлого, уулын чонын тоо толгой өссөн нутаг дэвсгэрт малчин иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг хамгаалах, уулын чонын тоо толгойг цөөлөх зорилгоор хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар,
3. Салбарын яамнаас ховордсон болон тоо толгой нь хэт өссөн ан амьтны талаар холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ